

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Агуулга

| | | |
|-------|---|----|
| 1 | Аудитын гэрчилгээ | 2 |
| 2 | Аудитын тайлан | 3 |
| 2.1 | Оршил | 3 |
| 2.2 | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 3 |
| 2.3 | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 4 |
| 2.4 | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 4 |
| 2.5 | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 5 |
| 2.6 | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 5 |
| 2.7 | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 6 |
| 2.8 | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 6 |
| 2.8.1 | Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал | 7 |
| 2.9 | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 7 |
| 2.10 | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга | 8 |
| 2.11 | Шилэн дансны мэдээлэл | 8 |
| 2.12 | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга | 8 |
| 2.13 | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл | 8 |
| 3 | Менежментийн захидал | 10 |
| 4 | Аудит хийсэн санхүүгийн тайлан | 11 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИЙН ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ
С.ЧУЛУУН ТАНАА

2019.03.07 № 06/398
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинжлэх ухааны академийн Түүх, археологийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Түүх, археологийн хүрээлэнгийн захирал С.Чулуун Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үндсэн хөрөнгийг тооллогын талаархи зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 10 дугаар сарын 3-наас 2018 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн “Шонхор үнэлгээ аудит” ХХК-ийн аудитор З.Эрдэнэжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/34 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат, шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн нь Үндэсний түүх, археологийн судалгааг тэргүүлэн явуулж, Монгол Улсын түүхийн бүх үеийн тулгамдсан асуудлыг археологийн дурсгал, түүхийн эх сурвалжид тулгуурлан шинжлэх ухааны өндөр түвшинд цогц судлагааг эрхлэн гүйцэтгэнэ гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Шинжлэх ухаан академийн ерөнхийлөгчийн 2017 оны А/73 дугаар тушаалаар Түүх, археологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Археологийн судалгаа
- Түүхийн баримт мэдээлэл
- Хүрэл, төмрийн судалгаа
- Хүннү ба эртний түүхийн судалгаа
- Бүс нутаг ба орчин үеийн түүхийн судалгаа
- Угсаатны судалгаа
- Археологи, угсаатны авран хамгаалах

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Инновацийн тухай хууль
- Технологи дамжуулах тухай хууль
- Шинжлэх ухаан, технологийн тухай хууль
- Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус хүрээлэнгийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд БСШУСпортын сайдын 2017 оны А/140 тоот тушаалаар батлагдсан “нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг ашиглаж байна.

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитын томилогдсон баг гүйцэтгэлээ.

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ “Санхүүгийн тооцоолох” ХХК-ны нягтлан бодох бүртгэлийн Acolous 4.01, Payroll програм хангамжийг 2015 оноос ашигласан байна.

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хариуцсан ажилтангүй болно.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн

үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Түүх, археологийн хүрээлэн нь 2018 онд улсын төсвийн санхүүжилтээс гадна нэмэлтээр дээд шатны төсөв захирагч болон гадаад дотоодын байгууллагын хандив, үйлчилгээний төлбөр зэрэг орлого орсонтой холбоотой юм.

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн 2018 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,794,941.3 мянган төгрөгийн 1 хувь 17,949.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцохдоо түүний тоон утгыг авч үзэхээс гадна алдааны шинж чанарыг харгалзан үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг

ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|-----|---------|--|
| 1 | Зөвлөмж өгсөн | 1 | 2,732.7 | Багц олон номыг 1 нэрээр бөөн дүнгээр бүртгэсэн. |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 1 | 45.0 | Үндсэн хөрөнгийн тооллого хийхэд 2 ширхэг ном дутсан |
| 3 | Албан шаардлага өгсөн | 0 | 0.0 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0.0 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0.0 | |
| | Дүн | 2 | 2,777.7 | |

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Аудитын явцад материаллаг хэмжээтэй алдаа зөрчил илрээгүй боловч дараах алдаа зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх үүрэг, тохиолдсон байх, үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн тооллогоор 45.0 мянган төгрөгийн үнэ бүхий 2 ширхэг ном дутагдсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т “байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-т “эд хөрөнгийн тооллого хийх журам”-ыг заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах, номны үнийг төлүүлэх төлбөрийн акт тогтоох

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 11 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,171,684.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,169,985.5 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа бөгөөд дийлэнх нь цалингийн болон гэрэл цахилгааны зардлын хэмнэлт гарснаас шалтгаалжээ.

Үндсэн үйл ажиллагаанаас 19,350.2 мянган төгрөгийн орлого олж, төлөвлөгөөг 1,649.8 мянган төгрөгөөр тасалсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Түүх, археологийн хүрээлэн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж үзэхэд тус хүрээлэнгийн цахим хуудсанд байршуулах 20 мэдээллээс 8 мэдээлэл оруулаагүй.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнэ бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ оруулах хэсэгт 3-10 сарын, мөн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг хэсэгт 7-9 саруудын мэдээллүүдийг хугацаа хоцруулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийг 2018 оны жилийн эцсийн байдлаар бүрэн биелүүлж ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг

байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Үндсэн хөрөнгийн тооллогын талаар

3.1.1 Илрүүлэлт

Хөрөнгийн тооллогод хийсэн ажиглалтаар номыг багцаар нь 2,732.7 мянган төгрөгөөр үнэлсэн.

Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдэлүүд болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.9 “эд хөрөнгийн тооллого хийх журам”-д заасантай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл

Үндсэн хөрөнгөнд тавих хяналт сулрах

3.1.3 Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 7 дугаар сарын 01-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|--------------------------------|--------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>145,619,341.94</u> | <u>167,197,615.26</u> |
| 33 | АВЛАГА | 47,836,095.87 | 22,602,803.37 |
| 335 | Бусад авлага | 47,741,561.87 | 22,383,645.37 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 47,741,561.87 | 22,383,645.37 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 97,783,246.07 | 144,594,811.89 |
| 351 | Түүхий эд материал | 27,500,685.15 | 2,108,999.98 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 27,500,685.15 | 2,108,999.98 |
| 354 | Хангамжийн материал | 70,282,560.92 | 142,485,811.91 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 24,853,293.46 | 9,460,879.98 |
| 35420 | Аж ахуйн материал | 44,009,267.46 | 50,338,133.46 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,420,000.00 | 22,922,798.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 00.0 | 59,764,000.47 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>862,840,738.42</u> | <u>2,439,844,619.19</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 862,840,738.42 | 2,439,844,619.19 |
| 392 | Биет хөрөнгө | 861,776,488.44 | 2,318,882,169.25 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,467,961,423.00 | 2,058,483,447.26 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,843,346,094.14 | |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 44,053,280.00 | 44,053,280.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -22,085,540.00 | -25,186,868.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 234,119,454.06 | 264,421,354.06 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -169,152,576.15 | -192,651,935.46 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 148,853,507.99 | 150,448,507.99 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -121,840,102.87 | -130,945,793.69 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 27,660,632.40 | 63,327,961.40 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -5,542,456.35 | -14,542,744.81 |
| 39217 | Ном | 101,094,960.50 | 101,474,960.50 |
| 393 | Биет бус хөрөнгө | 1,064,249.98 | 120,962,449.94 |
| 39301 | Програм хангамж | 6,430,986.11 | 6,430,986.11 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -5,366,736.13 | -5,681,336.17 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 00.0 | 120,212,800.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>1,008,460,080.36</u> | <u>2,607,042,234.45</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>12,338,493.89</u> | |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 12,338,493.89 | |
| 413 | Өглөг | 12,338,493.89 | |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 12,338,493.89 | |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>996,121,586.47</u> | <u>2,607,042,234.45</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 996,121,586.47 | 2,607,042,234.45 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,357,747,491.57 | 1,477,960,291.57 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,357,747,491.57 | 1,477,960,291.57 |

Түүх, археологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|------------|--|--------------------------------|--------------------------------|
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -431,773,025.49 | -464,184,957.41 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -431,773,025.49 | -431,773,025.49 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.0 | -32,411,931.92 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 70,147,120.39 | 1,593,266,900.29 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>1,008,460,080.36</u> | <u>2,607,042,234.45</u> |

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,577,560,138.00 | 1,794,941,265.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 16,119,867.00 | 58,050,206.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 16,119,867.00 | 58,050,206.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 16,119,867.00 | 58,050,206.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,873,705.00 | 18,450,206.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 462,000.00 | 900,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 784,162.00 | 38,700,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,561,440,271.00 | 1,736,891,059.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,131,178,900.00 | 1,150,684,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,131,178,900.00 | 1,150,684,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 430,261,371.00 | 586,206,359.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 87,759,835.00 | 236,538,258.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 237,616,900.00 | 217,654,675.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 104,884,636.00 | 132,013,426.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,625,299,685.71 | 1,827,353,196.92 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,625,299,685.71 | 1,827,353,196.92 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,578,739,304.27 | 1,822,141,597.05 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 982,955,667.85 | 1,066,665,576.31 |
| 210101 | Үндсэн цалин | 814,111,533.86 | 882,361,142.78 |
| 210102 | Нэмэгдэл | 136,785,240.36 | 104,414,506.62 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 32,058,893.63 | 35,364,256.00 |
| 210104 | Урамшуулал | 00.0 | 8,564,022.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.0 | 35,961,648.91 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 108,102,187.19 | 117,377,244.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 73,356,865.00 | 80,533,003.67 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,343,164.94 | 8,951,525.35 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,686,329.78 | 17,908,547.44 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,343,164.94 | 1,649,171.18 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,372,662.53 | 8,334,996.64 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 54,463,634.63 | 54,809,819.70 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 25,247,671.57 | 31,821,397.55 |
| 210302 | Түлш, халаалт | 24,818,976.00 | 19,542,127.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,396,987.06 | 3,446,295.15 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 26,864,744.36 | 28,626,028.78 |
| 210401 | Бичиг хэрэг | 00.0 | 2,961,655.90 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,796,210.00 | 13,360,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,950,534.36 | 1,905,155.58 |

Түүх, археологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 210404 | Ном, хэвлэл | 18,000.00 | 7,336,471.30 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 805,000.00 | 1,778,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 295,000.00 | 1,284,046.00 |
| 2105 | Нормативт зардал | 00.0 | 138,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.0 | 138,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,682,842.16 | 10,650,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,682,842.16 | 10,650,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 144,742,170.00 | 148,538,100.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 10,094,000.00 | 8,662,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 133,622,170.00 | 135,627,200.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 1,026,000.00 | 4,248,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 98,664,463.40 | 231,498,805.21 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 97,676,399.40 | 228,063,151.21 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 2,500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 553,740.00 | 515,830.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 248,500.00 | 196,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 175,824.00 | 223,824.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 10,000.00 | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 157,263,594.68 | 163,838,022.77 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 93,442,607.79 | 65,232,423.64 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 15,708,233.00 | |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 48,112,753.89 | 98,605,599.1 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 46,560,381.44 | 5,211,599.87 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 29,100,000.00 | 4,985,976.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.0 | 2,493,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.0 | 2,492,976.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 29,100,000.00 | |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 17,460,381.44 | 225,623.87 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 17,460,381.44 | 225,623.87 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -47,739,547.71 | -32,411,931.92 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -47,739,547.71 | -32,411,931.92 |

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,616,286,154.14 | 1,756,335,799.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 30,513,795.00 | 19,350,206.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 30,513,795.00 | 19,350,206.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 30,513,795.00 | 19,350,206.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,873,705.00 | 18,450,206.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,640,090.00 | 900,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,585,772,359.14 | 1,736,985,593.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,131,178,900.00 | 1,150,684,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,131,178,900.00 | 1,150,684,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 454,333,254.14 | 586,300,893.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 102,759,835.00 | 236,632,792.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 246,688,783.14 | 217,654,675.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 104,884,636.00 | 132,013,426.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,595,677,187.14 | 1,724,058,899.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,595,677,187.14 | 1,724,058,899.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,549,022,271.70 | 1,718,628,141.13 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 983,215,872.85 | 1,073,777,281.31 |
| 210101 | Үндсэн цалин | 810,693,786.21 | 889,472,847.78 |
| 210102 | Нэмэгдэл | 135,289,216.36 | 104,414,506.62 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 37,232,870.28 | 35,364,256.00 |
| 210104 | Урамшуулал | 00.0 | 8,564,022.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.0 | 35,961,648.91 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 95,763,693.30 | 122,229,725.05 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,018,371.11 | 81,338,769.57 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,343,164.94 | 9,781,439.71 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,686,329.78 | 19,209,832.06 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,343,164.94 | 1,955,215.26 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,372,662.53 | 9,944,468.45 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 54,463,634.63 | 54,809,819.70 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 25,247,671.57 | 31,606,419.55 |
| 210302 | Түлш, халаалт | 24,818,976.00 | 19,542,127.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,396,987.06 | 3,661,273.15 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 74,121,712.36 | 64,023,912.08 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,534,500.00 | 4,188,590.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 44,453,680.00 | 26,787,898.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,998,534.36 | 2,049,974.08 |
| 210404 | Ном, хэвлэл | 20,018,000.00 | 27,569,800.00 |

Түүх, археологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,524,100.00 | 1,778,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,592,898.00 | 1,649,450.00 |
| 2105 | Нормативт зардал | 715,000.00 | 780,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 715,000.00 | 780,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,489,642.16 | 10,728,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 806,800.00 | |
| 210604 | Урсгал засвар | 5,682,842.16 | 10,728,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 145,592,170.00 | 150,696,500.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 9,050,000.00 | 8,662,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 135,516,170.00 | 137,785,600.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 1,026,000.00 | 4,248,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 158,349,223.40 | 237,187,002.99 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 157,361,159.40 | 233,751,348.99 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 2,500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 553,740.00 | 515,830.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 248,500.00 | 196,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 175,824.00 | 223,824.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,311,323.00 | 4,395,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,178,090.00 | 4,395,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 15,133,233.00 | |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 46,654,915.44 | 5,430,757.87 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 29,100,000.00 | 4,985,976.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 2,493,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 2,492,976.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 29,100,000.00 | |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 17,554,915.44 | 444,781.87 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 17,554,915.44 | 444,781.87 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 20,608,967.00 | 32,276,900.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 20,621,067.00 | 32,276,900.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 20,621,067.00 | 32,276,900.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 20,621,067.00 | 32,276,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 20,621,067.00 | 32,276,900.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -20,621,067.00 | -32,276,900.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | -12,100.00 | 00.0 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 12,100.00 | 00.0 |

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-------------------------|------------------------|---|
| C01 | 2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,357,747,491.57 | 70,147,120.39 | -383,076,823.80 | 1,044,817,788.16 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | -956,653.98 | -956,653.98 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,357,747,491.57 | 70,147,120.39 | -384,033,477.78 | 1,043,861,134.18 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | -47,739,547.71 | -47,739,547.71 |
| C08 | 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,357,747,491.57 | 70,147,120.39 | -431,773,025.49 | 996,121,586.47 |
| D01 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,357,747,491.57 | 70,147,120.39 | -431,773,025.49 | 996,121,586.47 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,357,747,491.57 | 70,147,120.39 | -431,773,025.49 | 996,121,586.47 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 120,212,800.00 | 1,523,119,779.90 | | 1,643,332,579.90 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | -32,411,931.92 | -32,411,931.92 |
| D09 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,477,960,291.57 | 1,593,266,900.29 | -464,184,957.41 | 2,607,042,234.45 |

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Батлагдсан төлөвлөгөө | Зөрүү | Хувь |
|-----------------------|--|-----------------------|-----------------------|-----------------|--------|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,171,684,700.00 | 1,169,985,537.30 | 1,699,162.70 | 99.9% |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,171,684,700.00 | 1,169,985,537.30 | 1,699,162.70 | 99.9% |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,166,698,700.00 | 1,164,999,561.30 | 1,699,138.70 | 99.9% |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 921,991,900.00 | 921,338,609.62 | 653,290.38 | 99.9% |
| 210101 | Үндсэн цалин | 776,584,500.00 | 776,584,500.00 | - | 100.0% |
| 210102 | Нэмэгдэл | 104,513,000.00 | 104,414,506.62 | 98,493.38 | 99.9% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 35,400,000.00 | 35,364,256.00 | 35,744.00 | 99.9% |
| 210104 | Урамшуулал | 5,494,400.00 | 4,975,347.00 | 519,053.00 | 90.6% |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 114,607,800.00 | 114,539,678.90 | 68,121.10 | 99.9% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 78,227,800.00 | 76,335,255.53 | 1,892,544.47 | 97.6% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,095,000.00 | 9,140,602.52 | (45,602.52) | 100.5% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,276,000.00 | 17,952,794.37 | (10,676,794.37) | 246.7% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,819,000.00 | 1,828,119.30 | (9,119.30) | 100.5% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,190,000.00 | 9,282,907.18 | 8,907,092.82 | 51.0% |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 55,623,000.00 | 54,809,819.70 | 813,180.30 | 98.5% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 33,673,000.00 | 31,606,419.55 | 2,066,580.45 | 93.9% |
| 210302 | Түлш, халаалт | 18,910,000.00 | 19,542,127.00 | (632,127.00) | 103.3% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,040,000.00 | 3,661,273.15 | (621,273.15) | 120.4% |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 27,579,600.00 | 27,579,599.08 | 0.92 | 100.0% |
| 210401 | Бичиг хэрэг | 800,000.00 | 875,875.00 | (75,875.00) | 109.5% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 960,000.00 | 960,000.00 | - | 100.0% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,400,000.00 | 2,049,974.08 | 350,025.92 | 85.4% |
| 210404 | Ном, хэвлэл | 20,300,000.00 | 20,564,900.00 | (264,900.00) | 101.3% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,119,600.00 | 1,778,200.00 | 341,400.00 | 83.9% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,000,000.00 | 1,350,650.00 | (350,650.00) | 135.1% |
| 2105 | Нормативт зардал | 780,000.00 | 780,000.00 | - | 100.0% |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 780,000.00 | 780,000.00 | - | 100.0% |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 12,558,000.00 | 12,543,000.00 | 15,000.00 | 99.9% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,830,000.00 | 1,815,000.00 | 15,000.00 | 99.2% |
| 210604 | Урсгал засвар | 10,728,000.00 | 10,728,000.00 | - | 100.0% |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,000,000.00 | 6,000,000.00 | - | 100.0% |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,000,000.00 | 6,000,000.00 | - | 100.0% |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 27,558,400.00 | 27,408,854.00 | 149,546.00 | 99.5% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 23,973,200.00 | 23,973,200.00 | - | 100.0% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,500,000.00 | 2,500,000.00 | - | 100.0% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 606,700.00 | 515,830.00 | 90,870.00 | 85.0% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 248,500.00 | 196,000.00 | 52,500.00 | 78.9% |
| 210807 | Газрын төлбөр | 230,000.00 | 223,824.00 | 6,176.00 | 97.3% |

Түүх, археологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | | |
|---------------|---|------------------|------------------|----------------|--------|
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,986,000.00 | 4,985,976.00 | 24.00 | 100.0% |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 4,986,000.00 | 4,985,976.00 | 24.00 | 100.0% |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,493,000.00 | 2,493,000.00 | - | 100.0% |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 2,493,000.00 | 2,492,976.00 | 24.00 | 100.0% |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,171,684,700.00 | 1,169,985,537.30 | 1,699,162.70 | 99.9% |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,150,684,700.00 | 1,150,635,331.30 | 49,368.70 | 100.0% |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,150,684,700.00 | 1,150,635,331.30 | 49,368.70 | 100.0% |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 21,000,000.00 | 19,350,206.00 | 1,649,794.00 | 92.1% |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 13,500,000.00 | 18,450,206.00 | (4,950,206.00) | 136.7% |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,500,000.00 | 900,000.00 | 6,600,000.00 | 12.0% |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 97 | 97 | | |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 79 | 79 | | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 17 | 17 | | |

Төрийн аудитын байгууллагаас хийсэн санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын хураангуй тайлангийн хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2018.02.22

Аудитын нэр:

Санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код:

САГ-2019/49/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр:

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн

мянган төгрөгөөр

| № | Аудитын зорилт, чиглэл | Тоо | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | | | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|----------|----------------------------|----------|--|----------------|---------------------------------------|-------|--------|---|-----------------------|
| | | | | | Нэр | Огноо | Дугаар | Албан тушаал | Овог нэр |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | | | 9 | 10 |
| 1 | Балансын данстай холбоотой | 1 | Багц олон номыг 1 нэрээр бөөн дүнгээр бүртгэсэн. | 2,732.7 | Зөвлөмж өгсөн | | | Захирал Ерөнхий нягтлан бодогч | С.Чулуун О.Баярсайхан |
| 2 | Балансын данстай холбоотой | 1 | Үндсэн хөрөнгийн тооллогоор 2 ширхэг ном дутсан | 45.0 | Төлбөрийн акт тогтоосон | | | Захирал Ерөнхий нягтлан бодогч | С.Чулуун О.Баярсайхан |
| | | | Нийт | 2,777.7 | | | | | |

Баталгаажуулалт

Тайлангийн хураангуй бэлтгэсэн
Аудитор:

Анхан шатны чанарын хяналт
хийсэн: Чанарын хяналтын менежер

Д.Шийрэв

З.Эрдэнэжаргал

